



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 17/210

Мандалговь

Цолмон арт ХХК-тай гэрээ  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй “Өлзийт сумын жишиг гудамж талбайн дэд бүтэц, тохижилтын ажил”-ын зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Цолмон арт” ХХК-тай 47,033,463 (дөчин долоон сая гучин гурван мянга дөрвөн зуун жаран гурав) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зургийн даалгаврын дагуу “Өлзийт сумын жишиг гудамж талбайн дэд бүтэц, тохижилтын ажил”-ын зураг төсөв боловсруулах ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Цолмон арт” ХХК-ийн захирал (О.Цолмон)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л. ДОРЖБАТ

4822150529